



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 4/824

Ховд


Зарим үйл ажиллагааг түр
хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “в” заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 39 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэргийг бууруулах тухай” 209 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн хэмжээнд олон нийтийг хамарсан байгууллага, хамт олны шинэ жил, хурал цуглаан, спортын тэмцээн уралдаан, соёл урлагийн үйл ажиллагаа, тоглоомын газруудын үйл ажиллагааг 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр хүртэл түр хориглосугай.

2. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэн сурталчилж ажиллахыг сумдын Засаг дарга нар, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/824 Ch

02 4138